

**“Аргал”-ын тухайт үг хэллэгийн
угсаатны соёлын өвөрмөц шинж**

ОЮУНЦЭЦЭГ*

*Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль, Монгол хэлний тэнхим*

Дашдамбын ЭРДЭНЭСАН

*Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль, Монгол хэлний тэнхим*

Received: 25 August 2025 / **Accepted:** 18 September 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: Энэхүү өгүүлэлд монголчуудын нүүдлийн соёлын олон зуун жилийн явцад тогтоож бий болсон “Аргал”-ын соёлтой холбоотой өвөрмөц утгатай үг хэллэгийг цуглуулж тайлбарлахыг хичээлээ. Үндэстний ахуй, ёс заншлын баримт хэрэглэгдэхүүнийг хэл - соёл судлалын холбоо харьцаанд судлах нь монгол хэл, соёлын холбоо хамаарлыг тодруулахад онол хэрэглээний ач холбогдолтой юм. Халх, өвөр монголчуудын аргал түүх соёлтой холбоотой сонин содон үг хэллэг олон байна. Сонин содон гэсний учир нь эдгээр үг хэллэг нь аргал түүх, түлшээ бэлтгэх гэх мэт нийтлэг утгатай бус тухайн бүс нутаг, орон нутгийн ард түмэн ярьж хэлэлцдэгээрээ онцлог юм. Монголчуудын ахуй амьдрал цаг үеэ дагаад хувьсан өөрчлөгдөхийн хэрээр түлш бэлтгэх гол тэдний түлээ түлшээ бэлтгэх гол гол хэрэглэгдэхүүн болсон аргалын соёлыг тойрон хэчнээн олон төрлийн өөрчлөлт гарч ирснийг дээрх өвөрмөц үгсийн утгаас харж болно.

Түлхүүр үгс: Аргал – монголчуудын нүүдлийн соёл, аргалын түүх соёл, өвөрмөц утгатай үг хэллэг

**The Unique Ethnocultural Characteristics
of the Word ‘Aragal’**

WUYUNQIQIGE

*Department of Mongolian Language, School of Social Sciences and Humanities,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia*

ERDENESAN Dashdamba

*Department of Mongolian Language, School of Social Sciences and Humanities,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia*

* © Author(s), 2025, Email: wuyunqiqige6895@163.com



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

Abstract: *In this article, I have attempted to collect and explain expressions with unique meanings that are connected to the culture of argal—dried dung used as fuel—that developed over centuries within the nomadic traditions of the Mongols. Examining the everyday life, customs, and practices of a nation through the relationship between language and culture is theoretically and practically important for clarifying the close ties between the Mongolian language and culture. Among both Khalkha Mongols and Inner Mongols, there are many curious and distinctive expressions related to the history and culture of argal. They are considered distinctive because these expressions do not simply refer to the general meaning of argal or fuel preparation, but reflect the particular ways people of different regions and communities speak about them. As the living conditions of the Mongols have transformed over time, the meanings of these unique words show how many kinds of changes have taken place around the culture of argal, which served as the main means of fuel preparation.*

Key words: *Argal – Dried dung, Nomadic Traditions of the Mongols, History and Culture of Argal, with Unique Meanings*

1. Удиртгал

Угсаатан судлалын зарим нэгэн зүйл хэл ба хэлэхүйн онолын хөгжил хэрхэн өөрчлөгдөж хувьсаж ирсэнтэй холбоотой байна. Хүн төрөлхтөн малын баасыг өөрсдийн хэрэгцээндээ ашиглаж эхэлсэн цаг хугацаа эрт дээр үе гэдгийг судалгааны баримтууд харуулж байна. Ногоон бууцыг малын бууцтай зэрэгцүүлэн хэрэглэхийн ач тус, хөрсийг сайжруулахад гүйцэтгэх үүргийг эртний Грекийн түүхч Ксенофонт (МЭӨ 430-355) анх тэмдэглэсэн байдаг. (Aydeniz, 1985) Түүнчлэн угсаатны соёлын зүйлийг тухайн үндэстний хэл – хүнтэй холбон Америкийн индианчуудын соёлыг судалснаар чухамдаа хүн судлалын хэл шинжлэлийн (Anthropolinguistics) хэд хэдэн чухал таамаглалыг дэвшүүлсэн хүн судлаач, хэл шинжлэлч Эдвард Сэпир (1884 - 1939) далд ухамсар, бие хүн, хэл соёлын тухай ерөнхий онолыг дэвшүүлж, энэ нь шавь Б. Уорфын саналтай нэгдэж, хэл шинжлэлд “Сэпир Уорфын таамаглал”-ыг үндэслэсэн байдаг. Энэ цаг үеэс эхлэн угсаа хэл шинжлэлийн үндэс суурь тавигдсан хэмээн үздэг. Энэ тухай Жан Копан “Угсаатны болон аман хэл яриа, нөгөө талаас соёлын бүрэлдэхүүн хэсгийг үнэлэн үздэг хоёр талтай, тус ухааны онцгой нэгэн салбар угсаа хэл шинжлэлийн (l’ethnolinguistique) тухай ярих болсон байна. Энэ салбар ухаан бол утга зүйгээр дамжуулан соёлын болон оюун сэтгэлгээний загвар бүдүүвчийг задлан шинжлэх юм уу, аман зохиолыг задлан шинжилдэг, угсаатан судлал ямар нэгэн нийгмийн байгууламж юм уу практик үйлдлэгийг судалдаг шиг хэлний нийгэм, соёлын хэрэглээг харьцуулан шинжилдэг билээ” (2007: 94) гэсэнчлэн монгол хэл ба үндэстний соёлын харьцаа холбоог илэрхийлсэн нэгэн цогц ойлголт “Аргал” хэмээх хэл соёлын биеэ даасан үндсэн нэгж үүсэн бүрэлдсэн байна.

“Аргал” хэмээх үг хэллэг орсон монгол хэлний хэлц, зүйр цэцэн үгсээс жишээлэн үзвэл орон нутгийн онцлогтой холбоотой өвөрмөц зүйлс түгээмэл байдаг. Тухайлбал, зүйр цэцэн үгнээ “Амьд хүн аргатай, аргалын гал цогтой”, “Амьд хүн аргаа олдог, алтан хараацай үүрээ олдог”, “Нойтон аргал галын буг, нойрмог авгай гэрийн буг”, “Аргал түүхийн өмнө араг савраа урьтуул, ажил хийхийн өмнө арга ухаанаа урьтуул”, “Ах дүүгийн хол нь дээр, аргал усны ойр нь дээр”, “Аргалаас илч гарна, ажлаас тус гарна” зэрэг зүйр үг байхад Өвөр монголчуудын хэлэлцдэг “Гаднаа аргалгүй, гандаа усгүй”, “Айлыг нь үзэхээс, аргалыг нь үз”, “Ажилч бүсгүй айлын чимэг, аргал түлш хотны чимэг”, “Аргал нь онго цонго, айл нь ундуй сундуй”, “Тойромдоо аргалгүй, тулгандаа галгүй” гэх мэт зүйр цэцэн үгс байна. Эдгээр жишээ баримтад “тан, онго цонго, тойром” гэсэн үгс нь өвөр монголын орон нутгийн хэл ярианы онцлогийг хадгалсан шинжтэй юм. Эрдэмтэн Э.Равдан “Хэл – орон судлалын нэг гол судлахууны тулгуур мэдлэг” (2005:196) хэмээн үзсэн нь тухайн үндэстний соёлын концептын нэг бүрэлдэхүүн хэсэг болох үндэстний соёлын онцлог бүхий үг хэллэгийн тухай юм. Аргал болоод аргалын гал, аргалын утаа монголчуудын хувьд зүгээр нэг түлш түлээний тухай ойлголт бус бидний эх нутаг, байгаль дэлхий, орон нутагтаа оршин амьдрахуйн онцлогийг илэрхийлсэн угтаа нэгэн бэлгэдлийг агуулсан зүйл юм. Үүнийг олон жишээгээр тайлбарлаж болно. “Тулганы гал тогтуун сайхан дүрэлзэн ноцож, утаа нь бага байвал айл гэр өөдөлнө. Хэрвээ тулганы гал ноцохдоо муу, хар утаа баагиад байвал муу ёрын тэмдэг гэдэг. Хулангийн (яндангийн) утаа эгц

дээшээ суунаглан мандвал өлзий бэлгэд үзэж, байн байн зүгээ буруулаад байвал хийморь хэвтэнэ” (Түү Буян, 2023) гэж үздэг. Монгол ардын “Шалзат баахан шарга” дуунд “Аргалын хүн ажигч шүү, алсуур алсуур очоорой...” гэснээс аргал түүж явахдаа амьдарч байгаа орчин тойрон, айл хунар, цаг агаар, мал сүрэг болоод аливаа хэрэг бодисыг сайтар ажигж амьдрал ахуйгаа зохицуулж явдаг шинж илэрнэ. Аргалын утаагаа шинжиж дараа өдрийнхөө уур амьсгал ямар болох, малынхаа баасыг шинжиж алдуул малынхаа босож явсан цагийг магадлах, баасных нь байдлаар өвчин эмгэгийг нь шинжих зэрэг нутаг нутгийн онцлогтой зүйл ч байдаг. Байгаль дэлхий, нутаг орноо бишрэн хүндлэх, дээдлэн шүтэх сэтгэлгээг аргалаар дамжуулан илэрхийлсэн нь ч байна. Жишээлбэл, Ч.Чимэдийн “Би монгол хүн” шүлэгт “Аргалын утаа боргилсон малчны гэрт төрсөн би, атар хээр нутгаа өлгий минь гэж боддог” хэмээн аргалын утааны үнэрээр төрж өссөн өлгий нутгаа хайрлах сэтгэлийг илэрхийлсэн бол Ж.Балжиннямын “Морьтой монгол нутаг” шүлэгт “...алт аргалыг адилхан хормойлсон, арван гурван сум гол минь...” хэмээн аргалыг ч, алтыг ч аль алиныг миний нутаг наддаа харамгүй өгдөг гэсэн эх нутгаа хайрлах сэтгэлийг илэрхийлжээ. Энэ мэт бүхий л эхэд газар зүйн орчин тойрны тодорхой хэсгийг бодит дүрслэл, өөрөөр хэлбэл хүрээлэн буй бодит ертөнц, газар дэлхийн үнэн бодит байдлын дүр зургийг үзүүлдэг бөгөөд үүний дотор тухайн газар зүйн орчныг илэрхийлсэн соёлын биеэ даасан онцлог бүхий концепт үндэстний хэл бүрд байна. Үүний нэг жишээ болох “Аргал” хэмээх концептын хүрэн дэх “Аргалын гал”, “Аргалын утаа”, “Аргалын утааны үнэр”, “Гэрт оруулсан аргал”, “Гадаа овоолсон аргал” гэх үг хэллэгт нүүдэлчин монголчуудын ахуй амьдрал, газар зүйн орчны онцлог дүр зургийг харуулсан зүйл арвин байна. Нутаг орон, газар зүйн онцлог нь тухайн үндэстний соёлын бүрдүүлбэрийг хадгалдаг төдийгүй бүтээгч гэдгийн тухай судлаачид олон зүйлээр дурдаж баталсан байдаг.

2. Судалгааны арга зүй

Монгол үндэстэн угсаатны “Аргал”-ын соёлын адил ба ялгаатай талыг харьцуулан үзэхдээ судалгааны олон янзын бүтээлүүдийн үр дүнг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргаар адил ба ялгаатай талыг харьцуулах мета анализын арга, үг хэллэг нь үндэстний хэл соёлд хэрхэн тусгалаа олсныг ажиглан судлах угсаа хэл шинжлэлийн судалгааны аргуудыг хослуулан хэрэглэв. Судалгаанд “Аргал” хэмээх соёлын нэгжийн олон талт шинжийг илрүүлэх зорилгоор эрдэмтэн судлаачдын ном зүйд дурдсан бүтээлүүдийг үндэслэл болгон ашиглав. Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны ном бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлүүдээс гадна нүүдэлчин монголчуудын угсаатны зүйн баримтууд, монгол уран зохиолчдын зохиол бүтээл, бичгийн болон аман зохиолын эш баримтууд, нутаг нутгийн ард түмний аман ярианы баримтуудаас олж цуглуулж тайлбарлав.

3. “Аргал”-ын тухайт үг хэллэгийн угсаатны соёлын өвөрмөц шинж

Аливаа ард түмэн бүр оюун санааны соёлын амьдралынхаа явцад хэлний баялаг санг бүтээж ирсэн байдаг. “Аргал” хэмээх үг монголчуудын нүүдэлчин ахуй амьдралын олон зуун жилийн хөгжлийн явцад тэдний бүхэл бүтэн нэгэн соёл, үндэстний сэтгэлгээний онцлогийг хадгалсан нэгэн цогц ойлголт болон хөгжиж иржээ. Ийнхүү хэл, соёлын харилцан нөлөөллийг газар зүйн орчин, орон зайн шинжээс илрүүлж харвал, тухайн ард түмний хэл нь соёлоо бүрдүүлэхэд онцгой чухал нөлөө үзүүлдэг тухай эрдэмтэд олон зүйлээр тайлбарласан нь бий. Энэ тухай БНХАУ-ын эрдэмтэн Цан Жян Го “Газар зүйн орчин тойрон нь уугуул нутгийн ард түмний зан заншил, өвөрмөц дүр төрх, гоо зүйн таашаал сонирхлыг тусгадаг. Энэ үүднээс авч үзвэл орон зайнаас үүдэж хэл ярианд гарсан хувирал нь зөвхөн хэлний болоод газар зүйн үзэгдэл биш соёлын үзэгдэл юм. Тухайн орон нутгийн зан заншил, дадал зуршилтай уялдан соёлын нэгдэл бүрэлддэг. Хэл бол орон зайн цогц ойлголт, орон зайн хэллэг бол хэл юм.” (1992:71) гэжээ. Мөн Японы эрдэмтэн Хоуто Синшань “Хэл, утга зохиол, урлаг нь ардын зан заншилд хамаарна. Энэ нь голдуу нутгийн дуу шүлэг, зүйр цэцэн үгс, хэлц зэрэгт газар зүйн болон орон нутгийн соёлын өнгө төрх тусгалаа олсон байдаг” (1984:64) гэж үзсэн байна.

Аргалыг нэршлээр нь авч үзэхэд монгол нутгийн дөрвөн улирал ээлжлэх онцлогоос гадна хариулж байгаа малын төрөл зүйл, аргалын хөлдүү эсэх, чийг хуурайн хэмжээ, хэлбэр дүрсээр нь ялгаж нэрлэсэн нь түгээмэл байна. Японы эрдэмтэн Ёши Да монголчуудын аргалын тухай нэрийдлийг Японд зөвхөн нэг л нэртэй байхад монголчууд аргалыг нарийн төвөгтэй, олон янзаар нэрлэсэн байдаг гээд “бууц, ялгас, баас, аргал хомоол, хоргол, хөрзөн, өтөг, зунгаг, шар аргал, хар аргал, хөх аргал” (1992:82) гэх мэт 12 зүйлийн нэр олж тэмдэглэсэн байна. Мөн эрдэмтэн Бо Хай Ень ӨМӨЗО-ы Шилийнгол аймаг, Баяннуур хот, Улаанцав хот, Монгол Улсын Өмнөговь аймаг зэрэг газруудаар хээрийн шинжилгээний ажил хийж, таван хошуу малын баасны тухай “Малын баасыг ашиглах суурь болгож таван хошуу малын төрөл зүйл, улирал, таван хошуу малын нас шүд, баасных нь хөлдүү хэсэг, хуурай нойтон байдлыг үндэслэж нийт 34 нэрийдэл байна гэсэн бөгөөд хэдийгээр монголчуудын уран сайхны эхэд аргалын тухай нэрийдэл нь төдийлөн ялгаагүй боловч бодит амьдралд газар орныхоо онцлог ба хариулж байгаа малаасаа шалтгаалж аргалын нэрийдэл их зөрүү гардаг. Ийм нөхцөлд алиныг зөв хэмээн үзэж үндсэн нэршил болгоход хэцүү болдог” (2022:74) гэжээ. Үүнчлэн таван хошуу малын баасны нэршил газар орны онцлог, хариулж буй мал сүргийн байдал, үндэстний сүсэг бишрэл, зан үйл зэргээс шалтгаалж ялгаатай байдаг. Эрдэмтэн Бо Хай Ений “Монголчууд аргалыг өнгөөр нь ялган дүрсэлж нэрлэдэг нь өнгийг чухалчлан эрхэмлэдэгтэй холбоотой болов уу” (2022:179) гэсэн санал өвөрмөц юм.

Мөн тэрээр “Одоо болтол олдсон нэрийдлээс үзвэл монгол үндэстний дунд аргалын нэрийдэл 35, төвөдүүдийн дунд аргалын нэрийдэл 56 байна. Төвөдийн аргалын нэр нь голдуу аргалыг үйлдвэрлэж гаргасны дараах нэрийдэл болно” (2022:5) гэсэн дотор голчлон “Аргал түүх, аргал хураах, араг, савар” гэх мэт өдөр тутамдаа хэрэглэдэг түгээмэл нэрлэлтийг тоочиж гаргажээ. Харин ард олны энгийн ярианаас сурвалжилж олсон нутаг нутгийн хэлний баримтаас үзвэл аргалын өвөрмөц нэрийдэл олон байна.

4. Монголчуудын ‘аргал’-ын соёлын онцгой нэрийдэл бүхий үг хэллэгүүд:

Бид энэхүү судалгааны өгүүлэлд монголчуудын аргалын соёлын өвөрмөц онцлогийг илэрхийлсэн онцгой нэрийдэл бүхий дараах 51 үг хэллэгийг олж, ямар газар оронд, ямар утгаар хэрэглэдэг болохыг судалж тайлбарлахыг хичээв. Үүнд:

1. Аргал - аргасн

Үхрийн хатсан баасыг нийт монголчууд ерөнхийлөн ингэж нэрлэдэг. Ойрад баруун монголчууд, мөн алшаа монголчууд “аргасн” гэж ярина.

2. Аргалаа голлох

Өвөр монголчууд хашааны голоо шар аргал, хар аргал буюу шар хөрзөнгөөр дүүргэхийг аргалаа голлоно гэж хэлдэг.

3. Аргал задгайлах

Өвөр монголчууд хавар намартаа далан болгож хураасан аргалаа өвлийн эхэнд нээж түлэхийг “аргалаа задгайлна” гэдэг.

4. Аргал мантгайлах, нуруулах, малгайлах, саравчлах

Өвөр Монголын Улаанцав аймагт аргалаа суурилж хашаалж голлож баруун оройг нь дээш шовойлгон өндөрлөхийг хэлнэ. Үүнийг аргалаа нуруулна, аргалаа малгайлна, аргалаа саравчилна гэж бас хэлдэг.

5. Аргалын сумла

Алшаа аймгийн монголчууд аргалыг голдуу араг шээзгийгээр түүдэг бол тэмээний хорголыг сумла гэдэг саванд хийж түүдэг. Үүнийг “нэг сумла аргал”, “хоёр сумла аргал” хэмээн хэмжиж ярьдаг байна.

6. Бамбадаг

Говь-Алтай аймгийн халхчууд хорхой идсэн, хөвсгөр аргал түлш болоход муу тул ингэж нэрлэдэг.

7. Бор хомоол

Өвөр Монголын Тунляо, Шилийн гол зэрэг газарт нэг жилээс дээш сайн хатсан аргалыг ингэж нэрлэдэг. Монголчууд бол голдуу “хөх аргал” гэдэг.

8. Бор аргал, хөх аргал

Нар салхи бороо усанд элэгдсэн хомоол. “Бор хомоолоос албин гал үүснэ” гээд түлшинд огт хэрэглэдэггүй.

9. Боовон аргал

Өвөр Монголын Хөлөнбуйр аймагт монголчууд, бас төвөдчүүд ингэж ярина. Зун, намрын улиралд нойтон баасыг цуглуулан, шавар зуурах мэт сайн зуурсны дараа малын хашааны хэрэм дээр хүчтэй шавж наадаг, энэ нь таван хурууны оромтой бөгөөд дугуй боов хэлбэртэйгээс боовон аргал гэдэг. Хатсаных нь дараа ховхолж аваад түлдэг, гүйцэд найрсан болохоор илч нь тун сайн байдаг.

10. Гал манах

Монголчууд өдөр өдөр гал манаж, цаг цаг цог дардаг заншилтай гэдэг. Үүнийгээ малчид “Гал манаж, цог дарж амьдарна” гэж ярьдаг. Хөхөө өвлийн шөнө малчид галаа унтрахаас сэргийлэн, хөлдүү аргалаа тулганы үнсэн дотроо булж тавиад маргааш өглөө нь тулганы амсраа нээхэд аргалын хөх гал нь бадарсан хэвээрээ байдаг. Үүнийгээ монголчууд “галаа манах буюу голомтоо манах” гэж нэрлэдэг.

11. Дошсон сарлагийн бухын дунгуй

Баянхонгор аймаг Заг сумын халхчууд. Эрдэмтэн Б.Пүрэв-Очирын тайлбарласан нь: Дошсон сарлагийн бух олон өдрөөр зогсож, хэвтэж, идэж, хөрвөөж, сүр бараагаа үзүүлж явсаар, хаяахан нэг биеэ “хөнгөрүүлнэ”. Тэр нь сүртэй том, давхарласан, үелсэн, угалзалсан, хэд хэдэн үхрийнхийг нийлүүлсний дайтай. Нэг хоёр зуны усан бороог дааж, нэг хоёр хавар намрын хөх салхийг өнгөрөөж, элдүүр нь ханаад ирэхийн үес төмөр мэт том хөх аргал болно. Түүнийг нь дошсон сарлагийн бухын “дунгуй” гэж байгаа юм.

12. Дэлгээ

Баруун монголчуудын дунд ‘дэлгээ’ гэдэг үг байна. Увс аймгийн Эрдэнэмандал сумын Цэрэн-Ойдовын хатаасан дэлгээ аргалын зураг нийтийн сүлжээнд байна. Дэлгээ нь айлын ажилсаг, нямбай чанараас шалтгаалан өөр өөр байх бөгөөд бараг л “урлаг” болсныг энэхүү зургаас харж болно. Мод ихтэй хангай газар, төв халхчуудын дунд “дэлгээ” гэдэг үг байхгүй.

13. Ногооны аргал

Өвөр Монголын алшаа аймгийн монголчуудын хувьд аргал түүх нь аль дуртай цагтаа хийчихдэг ажил биш. Аргал түүхэд тохиромжтой хугацаа байдаг. Голдуу хавар, намрын улиралд түүнэ. Энэ нь зун, өвөл түлэх аргалаа бэлдэж байгаа хэрэг юм. Зуны улиралд малын баас ус ихтэй байдаг ба хур бороонд нордог, хорхой шавшинд идэгдэж нимгэрдэг зэргээс болж зун түлэх аргалаа хавар түүдэг. Хаврын сүүл, зуны эхний шинэ ногоо идсэн малын баасыг ногооны аргал гэнэ.

14. Ногоон хомоол

Өвөрмонголын Улаанцав аймагт зун намрын хомоолыг ингэж нэрлэнэ.

15. Ногооны хөрзөн

Өвөр Монголын Улаанцав аймагт зун, намрын улиралд гишгэсэн хөрзөнг ингэж хэлдэг.

16. Өвсний аргал

Өвөр Монголын алшаа аймгийн монголчууд намрын сүүл, өвлөөр хатсан өвс идсэн малын баасыг ‘өвсний аргал’ гэдэг. Нүүдэлчин монголчуудын хувьд ахуй амьдралтай салшгүй холбоотой байгалийн байдал болон хийж буй үйлдлээрээ цаг баримжаалах, илэрхийлэх олон өвөрмөц арга байдаг. Монголчуудын хувьд цаг хугацаа, жилийн дөрвөн улирал салшгүй холбоотой ойлголт юм. Тэд эрхэлдэг аж ахуй, ажил төрлийг цаг хугацааны утгаас салгах боломжгүй. Ирж буцах цагийг хавар, зун, намар, өвлөөр төлөөлүүлэхээс гадна эрхэлдэг ажил төрлөөр төлөөлүүлсэн нь арвин их байдаг.

17. Өжир аргал

Өвөр Монголын Улаанцав аймагт нэг жилээс дээш аяндаа хатсан аргалыг ингэж нэрлэдэг.

18. Өмх аргал

Хурдас гэсээд хатвал өмх аргал болдог. Өмх аргал нь зөөлөн байдаг тул амархан асдаг. Бутрамхай тул түлш болохдоо муу.

19. Сарьсан аргал

Өвөр Монголын Алшаа, Улаанцав, Шилийн гол аймгуудад зуны эхний ногоо идсэн үхрийн баас тун шингэн, хатахлаараа саарал өнгөтэй нимгэн сармигар аргал болдгийг ‘сарьсан аргал’ гэдэг. Сарьсан аргалын галын хүч саш буурай тул түлшинд бараг хэрэглэдэггүй.

20. Сэрмүүн аргал

Говь-Алтай аймгийн халхчууд гэрээсээ аль болох хол, цэвэр сэрмүүн газраас түүж ирсэн аргал илч сайтай, сайхан асдаг тул ингэж нэрлэдэг.

21. Таг

Өвөр Монголын Улаанцав аймагт хаврын эхээс намрын сүүлч болтол хүн малын хөлд гишгэгдэж бяцарсан хонь ямааны баасыг ингэж хэлдэг. Бас шалбаагийг нойтонд нь хамахгүй бол хатаж дагшраад таг суудаг.

22. Туйпуу цохих

Дорнод аймгийн Дашбалбар сумын буриадуудын дунд ‘туйпуу цохих’ хэмээн аргалын хогийг нүүрсний хогтой хольж хэвлэж хатаасан түлш бэлтгэхийг хэлдэг. Тэд мөн хөрзөн шивэх хэмээн нэрлэнэ.

23. Түнтүүл, түнтрэл, зүндүүл

Өвөр Монголын Хөлөнбуйр аймагт адууны хомоолыг “түнтүүл”, “түнтрэл”, “зүндүүл” гэдэг. Хөлөн буйрын баргачууд адууны хомоолыг “тунтуул” гэдэг. Монгол Улсын Дорнод аймгийн буриадууд “тонтоол”, баргачууд “тонтуул” гэдэг.

24. Тэнгэрийн хоргол

Өвөр Монголын Улаанцав аймагт тэмээний хомоолыг “тэнгэрийн хоргол” гэдэг. Тэмээ зогсоогоороо өндөр дээрээс хомоолоо унагадаг онцлог шинжээс нэрлэсэн бололтой.

25. Тэмээн аргал

Өвөр Монголын Алшаа аймагт тэмээний хорголыг ингэж нэрлэнэ.

26. Улаан аргал

Өвөр Монгол Шилийнгол, Тунляод өвлийн эхээр хатсан өвс идсэн үхрийн аргал улаан өнгөтэй болдгийг ингэж нэрлэдэг.

27. Урь

Булган аймгийн Тэшиг сумын хори буриадуудын дунд энэ үг байна. Халхчуудын хэлдэг “урь орох, урь идэх” хэмээх хэллэг эдгээр буриадын дунд “аргал бууц”-ны нэрийдэл болжээ. Энэ нь өвөлд малынхаа хэвтрийг цэвэрлээд хашааны гадна овоолоод хөлдөөгөөд байдаг аж. Хавар болоход овоолсон их бууц болдог. Түүнийгээ 5 сарын дунд хавьцаа үхэр тэргээр зөөж асгаад, дараа жилийн өвөл гэхэд овоолж асгасан өтөг нь хатаад овоолсон хуурай бууц болдог байна. Түүнийг дараа өвөлдөө малын хэвтэр хөлдөх үед сэлгэх хуурай бууц болгон буцааж ашигладаг аж. Үүнийг “урь” гэнэ. Өвлийн хүйтэнд малын хэвтэрт нэг ёсондоо дулаан хуурай урь болдог байна. Учир нь тэр нутагт мод ихтэй тул төдийлөн аргалаа түүж, овоолж хатааж түлшинд хэрэглэх хэрэгцээ төдий л үгүй тул ийнхүү хэрэглэдэг байна. Харин халхчууд болон, баруун монголчуудын дунд “урь” хэмээх үгийг ийм утгаар хэрэглэхгүй, харин “хаврын урь орох”, “хөлдүү мах урь идэх” гэсэн утгаар хэрэглэдэг байна.

28. Халтар аргал

Зуны улиралд сайтар хатаж энд тэндээ хөх саарал, хар холилдсон өнгөтэй болсон сайхан даргар аргал. Үүнийг сайн аргал хэмээн тооцно. Намрын сүүлч, өвлийн эхээр ногоон ногоо хатсан өвс хольж идсэнээс аргал нь хар алаг болдог тул нийт монголчууд ингэж нэрлэдэг.

29. Хар аргал

Өвөл, хавар хатсан өвс идсэн үхрийн баас нь хар өнгөтэй байдгаас нийт монголчууд “хар аргал” гэж нэрлэдэг. Хар аргалын гал хамгийн хүчтэй, амархан бялцардаггүй/бяцардаггүй/. Зөөж тээхэд сайн.

30. Хар хомоол

Өвөр Монголын Улаанцавд хомоолыг “хар хомоол”, “бор хомоол” гэж хоёр янзаар нэрийддэг. Өвөл цагийн хомоолыг ийн нэрлэнэ.

31. Хар хөрзөн

Өвөр Монголын Улаанцав аймагт хавар гишгэсэн хөрзөнг ингэж нэрийддэг.

32. Хог

Өвөр Монголын Улаанцавд бог малын баасыг ерөнхийд нь хог гэж нэрлэдэг.

33. Хамхи, хөх хамхи

Хүн малын хөлд гишгэгдэж бяцарсан малын хуурай нунтаг баас.

34. Хөрзөн

Өвөр Монголын Улаанцав аймагт малын хөлд гишгэгдэж бяцарсан хуурай нунтаг баасыг ингэж хэлдэг.

35. Хөрзөнгийн хальс (ногоон хальс)

Өвлийн сүүлчээс хаврын эхэн болтол хүн малын хөлд гишгэгдэж, малын шээс ноос үстэй холилдон хатуурч зузаарсан малын баасыг нийт ар, өвөр монголчууд ингэж хэлдэг. Өвөр Монголын Улаанцав аймгийн зарим нутагт тагийг ингэж нэрлэдэг.

36. Хөх хомоол

Нийт монголчууд хоёр жилээс дээш хатсан хомоолыг ингэж нэрлэнэ. Ийм хомоолыг ариутгах чанартай гэж үздэг.

37. Хөх хөрзөн

Өвөр Монголын Улаанцав аймагт удаан жилийн хөрзөнг “хөх хөрзөн” гэдэг.

38. Хумхийн ус

Нийт монголчууд. Үхэр бэлчээртээ идэшлэх үед зогсоогоор баасан баас нь пялдгар дугуй хэлбэртэй байх бөгөөд зун намрын улиралд хонхорхойд нь тогтсон борооны усыг ингэж хэлдэг.

39. Хур аргал

Өвөр Монголын Улаанцав аймагт хавар намар хураасан аргал.

40. Хурдас

Өвөр Монголын Шилийнгол, Тунляо, Улаанцавын монголчууд өвлийн цагт хөлдсөн үхрийн баасыг ингэж хэлдэг.

41. Хуухаа хомоол

Завхан аймгийн Тосонцэнгэл сумын сартуулууд олон жил болсон хомоолыг ингэж нэрлэдэг.

42. Хүбэриг

Дорнод аймгийн Дашбалбар сумын буриадууд хүбэриг хэмээн торт шиг хэлбэртэй том сайхан аргалыг нэрлэдэг. Энэ нь орос хэлний “кворика” хэмээх дугуй том талхтай адилтган нэрлэж үүссэн үг бололтой.

43. Хэмэг

Өвөр Монголын Хөлөнбуйрт хонь ямааны хорголын хэмхэрэн нунтаг болсныг “хэмэг” (хомог) гэдэг. Хэмгийг овоолж хатаагаад өвөл, хаврын хүйтэнд үхэр тэмээний дэвсгэр болгодог.

44. Цагаан аргал, хувхай аргал

Өвөр Монголын Алшаа, Улаанцав аймагт жил өнжсөн, хаврын эхэн үеийн цагаан аргалыг хувхай аргал гэж хэлдэг. Нэг жил нар салхинд гандаж хатвал өнгө нь цагаан болдог. Нийт монголчууд цагаан аргалын галын илч муу гэнэ.

45. Цагаан хомоол

Өвөрмонголын Алшаа, Улаанцав аймагт зун, намрын хомоолыг ингэж нэрлэдэг.

46. Цуваа аргал

Үхрийн цувуулж баасан баасыг өвөр монголчууд ингэж хэлдэг.

47. Шар аргал

Үхэр намрын улиралд үр жимстэй шинэ ногоо идээд баасанд нь тос агуулагддагаас өнгө нь шар өнгөтэй болдгоос “шар аргал” гэдэг. Мөн ар, өвөр монголчуудын дунд ингэж хэлдэг. Галын хүч сайн. Нар салхинд хатаж хуурай болсон хөлдүүс.

48. Шар хомоол

Өвөрмонголын Алшаа, Шилийн гол, Улаанцавд намар цагийн хомоолыг ингэж нэрлэнэ. Ордос болон зарим нутагт өвөл хаврын хомоолыг ингэж нэрлэнэ.

49. Шар хөрзөн

Өвөр Монголын Улаанцав аймагт хог нь малын хөлд гишгэгдэн дагширвал “шар хөрзөн” суудаг буюу өвөл гишгэсэн хөрзөнг ингэж нэрлэдэг.

50. Шар таг

Өвөл хаврын улиралд хөрзөн гишгэх үед хорооны өнцөг булан буюу сүүдэр талд хөлдөж орхигдсон нимгэвтэр хөрзөнг хэлдэг.

51. Шигжир, чигжир

Өвөр Монголын Хөлөнбуйрын баргачууд өвлийн улиралд хонь, ямааны хоргол гишгэлэгдэн хэмхэрч, малын шээс болон цастай холилдон хатуурсныг “шигжир” гэдэг. Хавар гэссэний хойно хүрээр гишгэлэн улаж авч хатаагаад өвөл түлдэг. Шигжрийн галын илч маш их. Монгол Улсын Өмнөговийн халхчууд “чигжир” гэж хэлдэг.

5. Судалгааны үр дүн

Монгол хэлнээ газар зүйн орчин тойрны бодит байдлын дүр дүрслэл, хүрээлэн буй ертөнц, газар дэлхийн онцлог байдал, угсаатны соёлын өвөрмөц онцлог зэргээс шалтгаалан уул юмыг олон зүйлээр нэрлэж хэрэглэдэг онцлог байна. Аргалын тухайт 51 үгийг монголчуудын аргал түлшээ бэлтгэх соёлоос улбаалан түүвэрлэж гаргасан нь бидний судалгааны өгүүллийн гол агуулга юм. “Аргал”, “хоргол”, “хомоол” гэдэг үгс бол таван хошуу малын баасыг нэрлэн дуудах ерөнхий нэрийдэл мөн. Монголчууд малын баасыг түлш болгон хэрэглэхдээ хорголоос бусдыг “аргал” хэмээн нэрийднэ. “Аргал” гэдэг нь зөвхөн үхрийн хатсан баасыг л нэрлэсэн бол аргалын өнгө, чанар, хэлбэр, ямар улирлынх зэргээс хамааран монголчууд өвөрмөц содон олон янзын үгсээр нэрлэдэг байна. Гэхдээ жилийн дөрвөн улирал ээлжлэн солигдох онцлог шинж нь нутаг нутагт өөр байдгаас зарим тохиолдолд нэг үгийн утга өөр өөр нутагт адил бусаар ухагдах онцлог байгаа нь ажиглагдаж байна. Аргалын тухай нэрийдэл нь эл улс үндэстний амьдран байгаа газар орны онцлог, эрхэлж байгаа аж ахуй, адуулж байгаа малын төрөл зүйл, амьдралын зан дадал, соёлын сэтгэхүйгээсээ шалтгаалан адил бус байдаг. Энэ нь үндэсний сэтгэхүйн онцлогийг харуулж байгаа юм. Тухайлбал: Зарим нутагт намар цагийн хомоолыг шар хомоол гэдэг бол зарим нутагт өвөл хаврын хомоолыг ингэж нэрлэдэг байна. Эдгээрээс газар зүйн орчин тойрны тодорхой хэсэг, хүрээлэн буй ертөнц, тухайн орчин газар зүйн орчныг илэрхийлсэн соёлын биеэ даасан онцлог бүхий концепт үндэстний хэл бүрд байдгийн нэгэн жишээ бол “аргал” хэмээх үг юм. “Аргал” хэмээх цогц ойлголт нь нүүдэлчин монголчууд оршин амьдарч ирсэн байгалийн орчныг тусгасан байдаг тухай эрдэмтэн Б.Пүрэв-Очир “Дошсон сарлагийн бухын дунгуй” бол сарлагтай газрын үг, хангайн үг, ер нь нутгийн аялгууны онцлогтой үг гэдгээрээ өвөрмөц юм.” (2013:221) гэсэн байдаг. Хятадын эрдэмтэн Цан Жян Го “Хэл нь нэг зүйлийн соёлын үзэгдэл болсны хувьд түүнд орон зайн бүрэлдүүлбэр зайлшгүй нөлөөлдөг юм. Учир нь хэл хэрэглэж байгаа нийгмийн бүлэг ямар нэгэн газар зүйн орон зайн бүтцэд хязгаарлагдаж байдаг бөгөөд иймэрхүү орон зайн соёл, түүний үзэл бодлыг бүрэлдүүлж байдаг. Иймээс орон зайн соёлын тухай сэрэхүй нь тухайн үндэстний өвөрмөц онцлог бүхий үгсийн сангийн тогтолцоо, хэлний зүйн арга барил, зан заншил, цаашилбал найруулгын арга барилтай болгосноор орон зайн соёл дахь үг хэлний соёлыг бүрэлдүүлдэг байна. Орон зайн соёл нь хэлний харилцааны арга барил, уран сайхны онцлогийг бүрэлдүүлэхээс гадна хэлний хэв маягийг төлөвшүүлдэг. Газар зүйн өөр өөр онцлог нь үзэл суртал, зан чанарын онцлог сонирхлыг төлөвшүүлэхэд тодорхой нөлөө үзүүлдэг тул газар зүйн өөр өөр орчинд өөр өөр хэлний хэв маяг бүрэлддэг” (1992:82) гэж үзсэн байдаг. Аргалыг нэршлээр нь авч үзэхэд монгол нутгийн дөрвөн улирал ээлжлэх онцлогоос гадна хариулж байгаа малын төрөл зүйл, аргалын хөлдүү эсэх, чийг хуурайгийн хэмжээ, хэлбэр дүрсээр нь ялгаатай нэрлэсэн нь олон байна.

Монгол хэлний “хөрзөн, бууц, ялгадас, баас, аргал, хомоол, хогол, хөрзөн, өтөг, зунгаг, шар аргал, хар аргал, хөх аргал, цагаан аргал, чацга, хумх, шаваас, хатсан аргал, өмх аргал, хурдас, түндүүл, түнтрэл, хар хомоол, шар хомоол, хөх хомоол, тэмээн хоргол” гэх мэтийн аргал түлшний холбогдолт олон янзын үг хэллэг нь жилийн дөрвөн улирлын олон янз өнгө хувирал, аргал түлш бол нүүдэлчин монголчуудын амьдралын салшгүй нэгэн хэсэг болохыг харуулж байна.

6. Дүгнэлт

6.1. “Аргал”-ын тухайт үгс нь монголчуудын амьдралын явцад бүтээсэн, бие даасан нэгэн соёл, бодит ертөнцийн юм үзэгдэл нь соёл болж хэвшин тогтдогийн үлгэр жишээ, хүн мал хоорондын хүмүүнлэг харьцааны үлгэр дуурайл болсон нэгэн бүхэл бүтэн цогц ойлголт болж ирсэн байна.

6.2. Аргал нь монгол хүнийг, монгол хүн нь аргалыг тодорхойлох хэл соёлын салгаж болшгүй холбоо харьцаа байна хэмээн үзэж болохоор байна.

6.3. Монгол үндэстний бүтээн бий болгосон эдийн болон оюуны соёлын зүйлсийн тухай урьдаас өөрсдөө танин мэдэж, улмаар ухамсар ой ухаандаа загварчлан хэвшүүлсэн ухагдахуун ойлголт, түүнийг тэмдэглэж нэрлэсэн хэлний тэмдгийн утга нь үндэстний сэтгэлгээний хэв шинжит хэмжүүр болдог байна.

6.4. Монгол нутаг маш өргөн уудам тул нийт монгол үндэстний аргалын соёлын нийтлэг шинжээс гадна нутаг нутгийн газар орны өвөрмөц ёс заншил бас байна. Үүнийг нутаг нутгийн үг хэллэг, зан үйлийн жишээ баримтуудаас үзэхэд сонирхолтой зүйл их байна.

6.5. Монгол хүн эх нутаг, газар усаа хэрхэн таньсан, тэрхүү таньсан байдлаа амьдрал ахуйдаа хэрхэн ашигладаг, хэлэндээ хэрхэн нэрлэсэн зэргийг танихуйн хэл шинжлэл, соёл хэл шинжлэл, угсаа хэл шинжлэлийн үүднээс “аргал” хэмээх ухагдахууны хүрээн дэх хэлний олон зүйл баримтаар гаргаж ирэх боломжтой байна.

Ном зүй:

А. Монгол хэлээр

Пүрэв-Очир, Б. (2013). *Судалбар эсээнүүд*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК. [Purev-Ochir, B. *Sudalbar esseenüüd* [Essays in Research]. Ulaanbaatar: Mönkhiin üseg LLC. 2013.]

Сампилноров. (1999). *Монгол малжлын соёл зүй*. Хөх хот: Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. [Sampilnоров. *Mongol maljlyn soyol züi* [The Cultural Anthropology of Mongolian Animal Husbandry]. Hohhot: Inner Mongolian People's Press Committee. 1999.]

Түү, Буян. (2023). *Аргалын соёл*. Хөх хот: Өвөр Монголын шинжлэх ухаан, техникийн мэргэжлийн хэвлэлийн газар. [Tuu, Buyan. *Argalyn soyol* [The Culture of Dung]. Hohhot: Inner Mongolia Science and Technology Professional Press. 2023.]

Б. Гадаад хэлээр:

Бо Хай Ень. (2022). *Хятадын дотоод эх хуурай дахь малын бууцны уламжлалт экологийн ухааны судалгаа*. Бээжин: Дундад Улсын Ардын утга урлагийн хэвлэлийн хороо. [Bo Hai Yan. *Khyatadyn dotood ekh khuurai dakhi malyn buutsny ulamjlalt ekologiin ukhaany sudalгаа* [A Study of Traditional Ecological Knowledge of Livestock Manure in Mainland China]. Beijing: China National Folk Literature and Art Publishing House. 2022.]

Гоу Цан Жан. (1992). *Соёлын хэл шинжлэл*. Леонгийн сурган хүмүүжлийн хэвлэлийн газар. [Gou Cang Zhang. *Soyolyn khel shinjlel* [Cultural Linguistics]. Liaoning Education Press. 1992.]

Ёшида. (1982). Аргал ба хоргол – монгол малын түлшний судалгаа. *Судалгааны өгүүлэл*. №3, 1982, 64. [Yoshida. Dung and Manure – A Study of Mongolian Animal Fuel. *Sudalgaany ögүүлэл*, 1982, 3: 64.]

Нишигава. (1972). Монголын нүүдэлчдийн үйлдвэрлэсэн цагаан идээний шинж чанар, нэрсийн талаарх судалгаа – өмнөх судалгаануудтай харьцуулахад. *Судалгааны өгүүлэл*. №3, 1972, 309. [Nishigawa. A Comparative Study of the Qualities and Names of Dairy Products Produced by Mongolian Nomads. *Sudalgaany ögүүлэл*, 2007. 3: 309.]

Хиото Синшань (1984). Угсаатны зүй. Бээжин: Дундад Улсын Ардын утга урлагийн хэвлэлийн хороо. [Hioto Shinshan. *Ugsaatni zui* [Ethnography. Beijing: China National Folk Literature and Art Publishing House. 1984.]